

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСАТАГ-2019/5/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойр

2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 7054-3151
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Утас: 7054-3179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn
Аудитор: Б.Дарханбат
Утас: 7054-3179
Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	* 9-11
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	132-16
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	17-26



**ГОВЬСУМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, № 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govicumber@audit.gov.mn

ГОВЬСУМБЭР АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Б.ОТГОНЧИМЭГ ТАНАА

2019.02.21 № 05
танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар”-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аudit хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Говьсүмбэр аймгийн “Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар”-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аudit хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Говьсүмбэр аймгийн “Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар”-ын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус хэлтэст мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аudit тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дунд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланда тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бodoх бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн захирагч Б.Отгончимэгт танилцуулж байна.

Энэхүү тайландаа үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлзээ.

Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.25-наас 2019.02.21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Дарханбат хариуцаж хэрэгжүүлэв.

Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2019.01.15-ны өдрийн 01/16 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайландаudit хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалыар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бodoх бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь Төр, орон нутгийн удирдлагаас хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд газрын харилцаа, барилга, хот байгуулалт, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх замаар хүн амын ая тухтай, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын үйл ажиллагааны чиглэлийг Газрын тухай багц хууль болон холбогдох бусад хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах гэж тодорхойлжээ.

Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бodoх бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Газрын тухай хууль
- Газрын төлбөрийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- ХХАОТ-ын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бodoх бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайландаа материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бodoх бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бodoх бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын санхүү, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвшгээний байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар" нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бodoх бүртгэлийн Санхүүгийн тооцоолох компанийн "Acolous" програм хангамж ашигладаг байна.

Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дунд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс тооцов.

Материаллаг байдлын суурийг төлөвлөлтийн шатанд 3-р улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангаар тооцсон бөгөөд гүйцэтгэлийн шатанд 4-р улирлын санхүүгийн тайлангийн зардлын дүнгээр тооцох нь бодитой гэж үзлээ.

Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 289,385.4 мянган төгрөг бөгөөд түүний 1.5% болох 4,340.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.5%-иар тооцсон нь гүйцэтгэлийн шатанд нэмэлт горим сорил хэрэгжүүлсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дунд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 13 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 11 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 6 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Too	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	4,270.09	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	1,500.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	5	5,770.09	

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй
асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас Зөвлөмж өгөх асуудлыг
Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын
дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Тайлант онд лабораторийн үйл ажиллагааг сурталчилан таниулахаар
хуваарилсан зардлаас 1,500.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй
нийцэхгүйгээс гадна НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төсвийн тухай
хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

2.8.1.2 Орлого, зардлын бүртгэл тайлагнал

Санхүүгийн үр дүнгийн тайланд 61,049.2 мянган төгрөгийн газрын дуудлага
худалдааны дэнчинг орлого, зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй
нийцэхгүй байгаагаас гадна НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д заасныг
зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав.

2.8.1.3 Мөнгөн гүйлгээний тайлангийн бүртгэл тайлагнал

Нийгмийн даатгалын сангаас үзүүлсэн 88.9 мянган төгрөгийн хөнгөлөлтийг
мөнгөөр хүлээн аваагүй боловч мөнгөн гүйлгээний журналд бүртгэж тайлагнасан.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй
нийцэхгүй байгаагаас гадна НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д заасныг
зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав.

2.8.1.4 Мөнгөн гүйлгээний тайлангийн бүртгэл тайлагнал

Мөнгөн гүйлгээний тайланд 4,763.0 мянган төгрөгийн нэр данс зөрүүтэй, залруулгын давхардсан гүйлгээг орлого, зардлаар бүртгэж тайлагнасан.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаагаас гадна НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав.

2.8.1.5 Хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Өөрийн хөрөнгөөр барьсан 68,063.1 мянган төгрөгийн барилга, хашааны өртгийг хуримтуулж дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгээгүй, бараа материалын орлого, зардлаар тайлагнаж, үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй орлогоор бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаагаас гадна НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав.

2.8.1.6 Бараа материалын тодруулга тайлан

Бараа материалыас бусад байгууллагад шилжүүлсэн 66,212.7 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсанаар тайлагнаж, үйл ажиллагааны үр дүнд тусгасан.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаагаас гадна НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав.

2.8.1.7 Үр дүнгийн зардлын бүртгэл тайлагнал

Үр дүнгийн тайланд 1,964.0 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардлыг бараа ажил үйлчилгээний бусад зардлаар бүртгэж тайлагнасан.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал илэрсэнгүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар" чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 164,974.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 164,863.9 мянган төгрөг буюу 99.9%-тай байна. Үүнд тээврийн хэрэгслийн даатгал, оношлогооны зардал хэмнэгдсэн бөгөөд автомашин эвдэрч ашиглах боломжгүй болсонтой холбоотой байна. Мөн үндсэн үйл ажиллагааны орлогоос төвлөрүүлэх шилжүүлгийг 36.2 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайланда санхүүжилт 164,974.0 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 13,194.2 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын орлого 10,462.9 мянга, нэмэлт санхүүжилт дансны орлого 28,882.8 мянга, нийгмийн даатгалын сангаас олгосон хөнгөлөлт 88.9 мянга, нийт 217,602.9 мянган төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайлангаар санхүүжилт 164,974.0 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 13,194.2 мянга, дуудлага худалдааны дэнчин 61,049.2 мянга, авлагын барагдуулалт 1,402.7 мянга, нэмэлт санхүүжилт дансны орлого 28,882.8 мянга, нийт 269,502.9 мянган төгрөгийн орлого бүртгэсэн байна. *

Тайлант оны эхэнд 1,424.1 мянган төгрөгийн авлага, 688.9 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулж ажилласан байна.

Тайлант хугацаанд Газар зохион байгуулалт геодизи зураг зүйн газраас машин тоног төхөөрөмжийн дансанд 2,578.3 мянга, бараа материалын дансанд 7,884.7 мянга, нийт 10,462.9 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэн байна.

Бараа материалын данснаас 324.9 мянган төгрөгийн хөрөнгийг ГЗБГЗЗГ-ын даргын 2018 оны А/222 дугаар тушаал, өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр акталж данснаас хассан байна. Мөн тусгай зориулалтын дансанд бүртгэлтэй 66,212.7 мянган төгрөгийн үнэ бүхий хаягжуулалтыг аймгийн ИТХ-ын 2017 оны 59 дүгээр тогтоолын дагуу Сүмбэр сумын ЗДТГ-т шилжүүлжээ.

Барилга байгууламж дансанд өөрийн хөрөнгөөр барьсан барилгын материалын шинжилгээний лабораторийг 66,083.1 мянга, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 2,993.9 мянга, нийт 69,077.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, дахин үнэлгээний хороодол 1,616.6 мянган төгрөгөөр хасагдаж, 69,460.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Машин, тоног төхөөрөмжийн дансанд захиалагчийн хяналтын зардлаас 10,248.6 мянган төгрөгийн лабораторийн багаж хэрэгсэл, ГЗБГЗЗГ-аас 2,578.3 мянган төгрөгийн компьютер, нийт 12,826.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 177,829.6 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Тавилга, эд хогшлын дансанд захиалагчийн хяналтын зардлаас 1,447.2 мянган төгрөгийн лабораторийн тавилга, эд хогшил худалдан авч 14,580.3 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УОНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Говьсүмбэр аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сүл талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланда тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринеас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланда шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

Илрүүлэлт

Албан татвар ногдуулах жилийн орлогоос ХХОАТ-ын хөнгөлөлтийг тооцоогүй байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батlamж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, ХХАОТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заазлтыг тус тус зөрчсөн байна.

Хариуцах ажилтан

Дарга Б.Отгончимэг
Нягтлан бодогч Л.Туяа

Зөвлөмж

ХХОАТ-ын хөнгөлөлтийг жилийн татвар ногдуулах орлогоос тооцох

Эрсдэл

Нягтлан бодох бүртгэлийн дансны үлдэгдэл, гүйлгээг санхүүгийн тайлан, тодруулгад зөрүүтэй тусгасан байх

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

Илрүүлэлт

Анхан шатны баримтыг батлагдсан
маягтаар хөтлөөгүй.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.6,
Архивын Ерөнхий газрын даргын 2009
оны 68-р тушаалаар батлагдсан "Төрийн
албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар"-
ыг тус тус зөрчсөн байна.

Хариуцах ажилтан

Дарга Б.Отгончимэг
Нягтлан бодогч Л.Туяа

Зөвлөмж

Санхүүгийн баримтыг ноорог цаасан дээр
бэлтгэхгүй байх, архив албан хэрэг
хөтлөлтийн стандартыг мөрдөх

Эрсдэл

Анхан шатны баримтыг батлагдсан
маягтаар хөтлөхгүй байх

Төсвийн захирагчийн хариу

3.3 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт

Төвлөрүүлэх орлогыг жилийн эцэст бүрэн төвлөрүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Хариуцах ажилтан

Дарга Б.Отгончимэг
Нягтлан бодогч Л.Туяа

Зөвлөмж

Орлогын төвлөрүүлэлтэнд хяналт тавих, бүрэн төвлөрүүлэх

Эрсдэл

Орлогын төлөвлөгөөг биелэхгүй байх нь Хүлээн зөвшөөрсөн
хуулийн хариуцлага хүлээх эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу